

**“ХӨВСӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026.04.29

№06

Мөрөн

Хурал: Хөвсгөл аймаг Мөрөн сумын 8-р багт байрлах “Хөвсгөл Хүнс”ХК-ийн өөрийн хурлын заланд 2026 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 17.00 цагт эхлэв.

Хурал дараах бүрэлдэхүүнтэй болов.Үүнд:

ТУЗ-ийн дарга: Л.Дашцэрэн

ТУЗ-ийн гишүүд: С.Нэргүй, Л.Тэгшбаяр, Л.Тунгалаг

Д.Ган-Очир, С.Отгонбаатар,Ж.Сайнжаргал, Ц.Намхай

Хурлын ирцийг “Хөвсгөл Хүнс”ХК-ийн ТУЗ-ын Хурлын дарга 70.46 хувь байгааг мэдэгдэж хурлыг нээв.

ТУЗ-ын дарга Л.Дашцэрэн Хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцуулав.

-Компанийн санхүүгийн тайлан,түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

-2025 оны компанийн бизнес төлөвлөгөөний тайлан

-Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг батлах

-Хянан шалгах зөвлөлийн тайлан

-ТУЗ,Гүйцэтгэх удирдлагын төсөв

-ТУЗ сонгох

ТУЗ-ын дарга Л.Дашцэрэн: Компанийн санхүүгийн тайлан,түүнд хийгдсэн хараат бус аудитын тайлангын дүгнэлт мөн ТУЗ,гүйцэтгэх удирдлагын төсөв танилцуулав.

Гүйцэтгэх захирал Ж.Нацагбадам: Компанийн бизнес төлөвлөгөөний тайлан,

Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө гэсэн асуудлуудыг хэлэлцүүлэв.

Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр: Хянан шалгах зөвлөлийн тайланг танилцуулав.

2025 онд компани нь 7914600 төгрөгний ашигтай ажилласан тул нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг 30 төгрөг байхаар танилцууллаа.

Хурлын дарга: Л.Дашцэрэн дээрх асуудлуудтай холбоотой санал хүсэлтийг сонсоё.

Саналтай гишүүн байхгүй тул дараагийн асуудлыг хэлэлцэв.

Компаний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн сонгох тухай.

Гүйцэтгэх захирал Ж.Нацагбадам: ТУЗ-ын гишүүдэд Л.Дашцэрэн, Ц.Мөнх-эрдэнэ, Л.Тэгшбаяр, С.Нэргүй, Л.Тунгалаг, С.Отгонбаатар, Ц.Намхай, Ж.Сайнжаргал, Д.Ган-Очир нарыг ТУЗ-ын гишүүнээр сонгох тухай саналыг оруулав.

Санал хураалтанд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжигдсэнийг тооллогын комиссын дарга Ж.Алтангэрэл танилцуулав.

Гүйцэтгэх захирал Ж.Нацагбадам: 2026 онд компанийн хэмжээнд дараах зүйлүүдийг бизнес төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж ажиллаж байгаа талаар танилцуулав.

-Үйлдвэрлэлийн чанарын хяналтыг улам сайжруулах, дотоод хяналтын тогтолцоог нарийн зохион байгуулалтанд оруулж, тусгай журманд оруулж хүнсний үйлдвэрлэлийн эрүүл ахуй стандартыг чанд мөрдөж ажиллах

-Талх нарийн боовны нэр төрлөө олшруулах, лаазалсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн орчин үеийн шинэ шугамыг ашиглалтад оруулах, үйлдвэрлэлийн хэмжээнд тоног төхөөрөмжийн хэсэгчилсэн бүрэн шинэчлэлт хийх

-Бүтээгдэхүүний сав баглаа боодлоо илүү сайжруулж мини савлагаатай болгох зорилтот бүлэгт чиглэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх

-Талх нарийн боовны үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлт хийх'орц жорын сонголт' норм,түүхий эд материалын,бүтээгдэхүүний чанарын сайжруулалтыг иж бүрнээр нь хэрэгжүүлнэ.

-Нөөшилсөн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх нөөшилсөн бүтээгдэхүүний цехийн ашиглалтын түвшинг нэмэгдүүлэх 'мах нөөшлөх,хатаах,савлах,утах гэх мэт.

-Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах бүх талын арга хэмжээг шат дараатай зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

- Нэрийн дэлгүүрийн тоог нэмэгдүүлж хүн хүн амын төвлөрөл ихтэй зах худалдааны төвд 1-2 үйлчилгээний төвтэй болох.

-

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурал 18.40 минутанд хаав.

ТАНИЛЦСАН ТУЗ-ЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



Л.ДАШЦЭРЭН

Т.БЯМБАЖАРГАЛ